



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/45

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 03 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал маллагааны уламжлалт аргыг эзэмшин, нийгэмд үзүүлж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын аварга малчнаар шалгарсан дараах нэр бүхий малчдыг тус бүр 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгний дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсугай.

- |                                |   |
|--------------------------------|---|
| 1. Балжир овогтой Тагарваа     | Дэлгэрцогт сумын Баянбулаг багийн малчин      |
| 2. Нацаг овогтой Ганхуяг       | Гурвансайхан сумын Гурвансайхан багийн малчин |
| 3. Шар овогтой Ганхуяг         | Сайнцагаан сумын Тэвш багийн малчин           |
| 4. Бат-Очир овогтой Эрдэнэбаяр | Дэрэн сумын Саруул багийн малчин              |
| 5. Ёндонжамц овогтой Өлзийбат  | Адаацаг сумын Ар урт багийн малчин            |

Хоёр. Шагналд шаардагдах нийт 2000.000 / хоёр сая / төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын Газрын Дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ч.Даваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



020000102